

**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 2026/01

Улаанбаатар хот

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цаг 00 минутанд “Улаанбаатар БҮК” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэл 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11:30 цаг хүртэл явагдаж дуусав.

Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Нямхүү даргалав.

Тооллогын комисс-д Д. Пүрэвцэрэн, Л. Билгүүн, Д.Ууганцэцэг нар тус тус ажиллав.

Мөн хуралд Хараат бус гишүүн бөгөөд Гүйцэтгэх захирал Г.Ганболд оролцов.

Хурлын ирц:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт

131 5 47 500 ширхэг саналын эрхтэй хувьцааны 128370352 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 97,58 хувийг төлөөлсөн 30 хувьцаа эзэмшигч оролцсон тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу “ирцийг хүчин төгөлдөрт тооцох” талаарх Тооллогын комиссын шийдвэрийг Комиссын дарга Д. Пүрэвцэрэн хуралд оролцогсдод танилцуулав.

Хуралд 2026 оны 4 сарын 22-ны өдөр Компани дээр биеэр ирж урьдчилсан байдлаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигчид:

№	Овог	Нэр	Хувьцааны тоо	Регистрийн дугаар	Тайлбар
1	Учрал	Батболд	5	УК67090911	Дашдэндэв овогтой Отгоны итгэмжлэлтэй
2	Дашдэндэв	Отгон	5	ЧЙ69112701	
3	Батболд	Цэлмүүн	5	УП03240441	Дашдэндэв овогтой Отгоны итгэмжлэлтэй
4	Сумьяа	Уранчимэг	19	УЖ62022600	
5	Намсрай	Чимэдлхам	5	УХ51030462	
6	Дорж	Янжмаа	300	РЭ54032485	
7	Дагвадорж	Баярмаа	25	ЧТ71110707	
8	Жамба	Баатар	5	11083150466	
9	Баатар	Баттулга	4	103116762349	
	НИЙТ		373		

ХУРАЛД БИЕЭР ОРОЛЦОЖ САНАЛ ӨГСӨН					
№	Овог	Нэр	Хувьцааны тоо	Регистрийн дугаар, иргэний бүртгэлийн дугаар	Тайлбар
1	Сандагжав	Данцдорж	75	ЧЗ71031200	
2	Нэргүй	Бурмаа	410	ХА62122268	
3	Ойдов	Гарамханд	15	ХЙ54110503	
4	Мягмаржав	Шигшээ	11	ХБ74122819	
5	Данцэрэн	Урнаа	70	ЧЛ69042663	
6	Пунцаг	Цогзолмаа	50	112503340749	
7	Мөнхбаатар	Оюундарь/БИ ДИСЕК ҮЦК ХК/	31340	2052482	М.Оюундарь төлөөлж оролцсон.
8	Батсуурь	Мөнгөнцацрал	10	ЧП85081209	
9	Баасанжав	Энх-Амгалан	15	111900320553	
10	Цогтоо	Хосбаяр	3	ОЮ94041831	
11	Баатар	Оюунбилэг	2	111098951157	
12	Даваасүрэн	Батсайхан	10	640179591956	
13	Сүрэнжав	Пүрэвжав	15516	111014631064	
14	Сурмаажав	Мягмарсүрэн	12	111694742821	
15	Батболд	Ариунболд	5	111694742821	
16	Мөнхөө	Долгөөн	6484	111950662337	
17		"УБ менежмент"	128315700	2662736	Төлөөлсөн: Менежер Хамхоев овогтой Магомед Басир
18	Батсуурь	Ганбаяр	1	ЧП82041716	
19	Мондоон	Оюунбулган	30		
20	Жадамба	Энхтунгалаг	200		
21	Чогсом	Мөнхбаяр	20	110702461999	
	нийт танхимаар оролцсон		128369979		

4 сарын 22-ны өдөр урьдчилж санал өгч хуралд оролцсон ба 4 срын 30-ны өдөр хуралд оролцсон нийт 128370352 /373+128369979/ ширхэг хувьцаа эзэмшдэг 30 хувьцаа эзэмшигчийг ирцэд бүртгэв.

Хурлын эхэнд Хурал даргалагч Д.Нямхүү шинэ хувьцаа эзэмшигчдэд хандан Компанийн үйл ажиллагаа, ололт амжилт, сүүлийн үеийн тулгамдсан асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

Хурал даргалагч Д.Нямхүү хурлын дэгийг танилцуулсныг хуралд оролцогсод бүгд дэмжин батлав.

Хэлэлцэх асуудал:

1. Хэлэлцэх асуудал-1: 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;

2. Хэлэлцэх асуудал-2: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг батлах;

3. Хэлэлцэх асуудал-3: ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсөв батлах;

Хэлэлцэх асуудал-1:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Г.Ганболд дараах байдлаар дэлгэрэнгүй танилцуулав.

2025 ОНЫ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Нийт үйлдвэрлэл	Нийт борлуулалт	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
31,016 м³	20,109 м³	34.6 тэрбум
Нийт орлого	Татварын өмнөх ашиг	Цэвэр ашиг
36,259,943	1,250,066	1,100,213
Нийгмийн даатгалд төлсөн	Татварын байгууллагад төлсөн	Нийт төлсөн
2,312,319	4,211,550	6,523,869
Нийгмийн даатгалын өглөг	Татварын өглөг	Нийт өглөг
1,263,732	816,731	2,080,463

Компанийн үйл ажиллагааны тайлангийн талаарх мэдээлэлтэй холбогдуулан хувьцаа эзэмшигч **С.Пүрэвжав** Ерөнхий болон удирдлагын зардал ихээхэн дүнтэй өссөн байгаа болон өглөг 28 тэрбумаар өссөн байгаа талаар тайлбар өгөхийг хүсэв.

Гүйцэтгэх захирал Г.Ганболд: зардалд хамгийн их хувийг цалин хөлсний зардал эзэлж байгаа ба өнгөрсөн жил улсын захиалга, тендерт ажлуудыг цаг хугацаанд нь гүйцэтгэхийн тулд нийт 283 хүн ажилласан, тэдгээрийн цалинг нэмэгдүүлэн илүү цагийн хөлс, баяр ёслол, амралтын өдрүүдээр ажиллуулсны нэмэгдлийг олгосон. Үүн дээр НДШ, татварын хураамжууд өглөг нэмэгдэхэд хүргэсэн. 2026 онд 2025 оны авлага барагдуулах арга хэмжээ хэрэгжсэнээр өглөгөө бууруулж ажиллаж байна. Энэ байдлаар 2026 онд өглөгийн тооцоо дуусгах таатай нөхцөл бүрдэнэ, тэр чиглэлээр арга хэмжээ авч ажиллаж байна.

Д.Нямхүү нэмж дараах мэдээлэл хийв, үүнд: Ажилтнуудын цалинг нэмэхэд нөлөөлөх гол хүчин зүйл нь үйлдвэрийн ажилтнуудыг сургаад дадлагажуулаад байх явцад ажилтнууд ажлаас их гарах, Солонгос явж ажил эрхлэх шалтгаанаар ажлаас гарах хөдөлгөөнд нөлөөлсөн, иймд цалинг үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байгаа гэв.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнгөнцацралын ..улсаас авах авлага удаашралтай, хүндрэлтэй байгаа ..тухайд тайлбар хийхийг хүсэхэд Г.Ганболд УБТЗ гэх мэт төрийн өмчит компаниуд төсвийн хүндрэлтэй гэх шалтгаанаар зарим тохиолдолд мөнгө төлбөр гүйцэд орж ирэхгүй удааширдаг талаар мэдээлэл өгөв.

Хувьцаа эзэмшигч Б.Ганбаяр ...улс тендерийн мөнгөө өгөхгүй байна уу, эсвэл төрийн тендерт орсон компаниуд захиалгаар хийлгэсэн бүтээгдэхүүний мөнгийг өгөхгүй байдаг уу.. гэх асуултанд Г.Ганболд, тендерт ороод томоохон захиалга хийлгэж байгаа компаниуд улсын төсвийн хүндрэлээс хамаарч төлбөрийн байдал дээр удааширч байна, гэхдээ он гараад авлага орж ирж байна, 2026 онд хийх зүйл их байгаа гээд гол гол ажлуудаас дурдав.

Асуулт хариулт дууссан тул 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах шийдвэр Д.Нямхүү танилцуулж санал хураав.

Санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 1

Санал хураалтын дүн: 99,9%

ШИЙДВЭР:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “хангалттай” гэж батлах.

Мэдээлэл өгөх:

Д.Нямхүү 2025 оны санхүү тайлангийн үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг уншиж танилцуулав.

Хэлэлцэх асуудал-2:

ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай:

Хурал даргалагч Д.Нямхүү ТУЗ-д 9 хүнийг нэр дэвшүүлэхээр Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан шийдвэрийг, тэдгээр гишүүдийн танилцуулгын хамт танилцуулав.

Нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийн дагуу ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдэд хуралд оролцогсод куммулятив аргаар саналаа өгснийг нэгтгэж дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

1.Ердийн гишүүдэд

Д/д	Нэр дэвшигч	Нэр дэвшигчдэд өгсөн саналын тоо
1	Д.Нямхүү	128739897
2	Д.Мөнхөө	128316814
3	Х.Ю.Хамхоев	128316814
4	М.А.Чапанов	128316814
5	Н.Ханбулаг	128316814
6	Д.Сувд	128375260

2.Хараат бус гишүүдэд нэр дэвшигч

1	С.Б.Громов	128316814
2	Г.Оюунболор	128316902
3	Л.Таня	128316814

ШИЙДВЭР:

1. “УЛААНБААТАР БҮК” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр дараах нэр бүхий хүмүүсийг томилох:

Ердийн гишүүд:

- 1.Д.Нямхүү

2. Д.Мөнхөө
3. Х.Ю.Хамхоев
4. М.А.Чапанов
5. Н.Ханбулаг
6. Д.Сувд


Хараат бус гишүүд

1. С.Б.Громов
2. Л.Таня
3. Г.Оюунболор

Мэдээлэл өгөх: Гүйцэтгэх захирал Г.Ганболд “Улаанбаатар БҮК”ХК-ийн 2026 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар дараах мэдээллийг танилцуулав.

Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөв байдал

2026 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ




САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЗОРИЛТУУД


Борлуулалт ба Нийт Ашиг (сая ₮)



Цэвэр ашгийн хувь (%) /татварын дараах/



Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг — EPS (₮)



Ажилтны тоо & Бүтээмж (сая ₮/хүн)



01	Байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг хариуцлага, харилцаа уялдааг тодорхой болгох	Бүтэц & Засаглал	05	Гар ажиллагааг багасгах — автоматжуулсан системүүд нэвтрүүлэх	Дигитал шилжилт
02	ISO нийцлийг бүрэн хангуулах	Мэдээлэл систем	06	Мэдээлэл урсгалыг шуурхай, хүртээмжтэй болгох	Мэдээллийн систем
03	Өртөг зардал, хайтгал хорогдол бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх	Санхүүгийн үр ашг	07	Бүтээгдэхүүний чанар тогтворжуулах	Чанарын хяналт
04	Хариуцлагын тогтолцоог оновчтой KPI системтэй холбох	Үйлдвэрлэлийн удирдлага	08	Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх: сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх	Хүний нөөц
09	Цогц бодлого хэрэгжүүлж хөгжүүлэх	ХАЕЗАСО	10	Үйлдвэрлэлд осол аваргуй ажиллах	Асуулгүй байдал

2026 онд 20 хүрнэ 10 үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлжээ. Санхүүгийн тооцоогийн байдал, аж ахуйн байр суурь, бэлтгэмж, үр ашгийг сайжруулна.

Хэлэлцэх асуудал-3:

ТУЗ-ийн 2026 оны төсвийн талаар хурал даргалагч Д.Нямхүү дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн ба Компанийн 2026 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг **245,140,000 /хоёр зуун дөчин таван сая нэг зуун дөчин мянган/** төгрөгөөр батлах ТУЗ-ийн саналыг танилцуулж санал хураав.

Санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

Компанийн 2026 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг **245,140,000 /хоёр зуун дөчин таван сая нэг зуун дөчин мянган/** төгрөгөөр батлах

Хурал дэгийн дагуу 14.20 цагт дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН: Д.УУГАНЦЭЦЭГ

ХУРАЛ ДАРГАЛАГЧ: Д.НЯМХҮҮ

